



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ**

2016 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот


Тушаалын хавсралтыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн сайдын “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээний загвар батлах тухай” 2015 оны 41 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Техникийн хяналтын гэрчилгээний загвар”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.


2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын “Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээний загвар батлах тухай” 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 41 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



М.ЗОРИГТ

Зам, тээврийн сайдын 2016 оны 0/ дүгээр сарын 00-ны өдрийн 00 дүгээр тушаалын хавсралт



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

НҮҮР ТАЛ



АРТАЛ

Гэрчилгээ № 000001
Улсын дугаар:
Арлын дугаар:
Даатгалд хамрагдсан эсэх:
Татвар төлсөн эсэх:
Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан огноо, тамга: 20 ... он ... сар ... өдөр
20 ... он ... сарын ... өдөр хүртэл хүчинтэй.

2016-2019 онуудад олгогдох техникийн хяналтын гэрчилгээний дэвсгэр болон тооны өнгө нь:

1. 2016 он - дэвсгэр өнгө - шар, тоо – хар
2. 2017 он - дэвсгэр өнгө - хар хөх, тоо – цагаан
3. 2018 он - дэвсгэр өнгө - саарал, тоо – хар
4. 2019 он - дэвсгэр өнгө - ногоон, тоо - цагаан

Цаашид техникийн хяналтын гэрчилгээний дэвсгэр болон тооны өнгө нь дээрх дэс дарааллаар эргэж давтагдана.

Техникийн хяналтын гэрчилгээний ар тал нь тээврийн хэрэгслийн улсын дугаар, арлын дугаар, даатгал, татвар, техникийн хяналтын үзлэгт хамрагдсан огноог тусгасан болон хүчинтэй байх хугацааг заасан загвартай байна.